

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ
/ 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН БАЙДЛААР/

2022 оны 06 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Гарсан үр дүн	Үнэлгээний хувь	Хяналтаас гаргах тухай санал дүгнэлттэй эсэх
Ерөнхийлөгчийн зарлиг						
1	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.2. Жил бүр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний нэг хувиас доошгүй хөрөнгийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг үйл ажиллагаанд зарцуулах, улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын тодорхой хувийг байгальд ээлтэй, стандарт бүхий ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд зориулах эрх зүйн орчинг бүрдүүлж, холбогдох шийдвэр гаргах	<p>1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 20 дугаар тогтоолоор хотын стандартын "Ногоон байгууламж" бүлгийн 5 баримт бичгийг батлуулах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • UCS0801A:2022 Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлтийн удирдамж • UCS0802C:2022 Мод таримал ургамлын төрөл зүйлийн лавлах • UCS0803B:2022 Ногоон байгууламжийн арчилгаанд тавигдах шаардлага • UCS0802A:2022 Цэцэрлэгчийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны удирдамж • UCS0801C:2022 Цэцэрлэгчийн хөдөлмөрийн багаж хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн лавлах. <p>2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний төсөлд Нийслэлийн Байгаль орчны газарт 01/162 дугаартай албан бичгээр дараах саналуудыг хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлэх; 	Ногоон байгууламжид хамаарах хотын стандартын 5 баримт бичгийг батлуулсан.	90	үгүй

			<ul style="list-style-type: none"> • Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд нөхөн сэргээлт хийж, ойжуулах; • Хотын стандартын Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөвлөлт хийх удирдамж, арга зүйн 5 төрлийн баримт бичгийг хот, нийтийн аж ахуйн чиглэлд үе шаттайгаар мөрдүүлэх; • Мод тарьж ургуулахад шаардагдах усны нөөцийг бүрдүүлэх, ус хуримтлуулах хөв, цөөрөм /биосвайл/ үүсгэх, ус дахин ашиглах. 			
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2022-04-05 Дугаар 2022_43	1.4. Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулж буй албан ёсны баяр, ёслолын арга хэмжээ, хүлээн авалтад өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхийг бүрмөсөн хориглох;	Тус газраас төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс зохион байгуулсан баяр ёслолын арга хэмжээнд хамрагдаагүй болно.	Зөрчил үүсээгүй.	90	Тийм
3		2. Нийт иргэн, аж ахуй нэгж, байгууллага архи, согтууруулах ундааны хэрэглээ, түүнээс үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагаврыг бууруулахад санаачилгатай оролцох, баяр ёслол, тэмдэглэлт өдөр, ажлын байранд өндөр хатуулагтай этилийн спирт агуулсан архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байхыг уриалсугай.	Монгол улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хүрээнд байгууллагын ёс зүйн дүрмийг шинэчлэн баталсан. Ёс зүйн дүрмийн 3.4.7-д архи, согтууруулах ундааг хэрэглэхгүй байх талаар тусгаж, нийт албан хаагчдад танилцуулж ажиллав.			
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл						
4	Тэгш хамран сургах боловсролын	Бүх шатны сургалтын байгууллагын байгууламж, барилга нийтийн	Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/239 дүгээр захирамж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03	Стандартын шаардлагад хангуулсан.	70	Үгүй

	<p>талаар авах зарим арга хэмжээний тухай 2020-12-23 Дугаар 2020_235</p>	<p>эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөө, анги танхимыг хөгжлийн бэрхшээлтэй суралцагч ашиглах боломжтой стандарттай байхаар тоноглож, тохижуулах цогц арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх</p>	<p>сарын 24-ний өдрийн 18, 19, 21, 22, 23, 25, 26 дугаар тогтоолуудаар батлагдсан 9 бүлгийн 38-н Хотын стандарт, удирдамж арга зүйн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулахаар барилга байгууламж, их засвар, шинэчлэлтийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулан бүх шатны сургалтын барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлага, хүртээмжийн чанарыг сайжруулахад мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн гүйцэтгэгч байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажиллаж байна. Мөн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагаас Монголын хараагүй иргэдийн үндэсний холбоо, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоодоос хүртээмжийн үнэлгээний ажилтан тогтмол томилогдон ажиллаж байна.</p>			
5		<p>6. Бүх шатны сургалтын байгууллагын орчинд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангасан зохих стандартад нийцүүлсэн зам, талбайтай болгох арга хэмжээг 2021-2023 онд авч хэрэгжүүлэх</p>	<p>UCS1101B:2022 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчны ерөнхий шаардлага”, UCS1102B:2022 “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага” хотын стандартыг боловсруулан Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 19 дүгээр тогтоолоор батлуулсан. Дээрх баримт бичгүүдийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/1033 захирамжийн дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх” бүлгийн 2 хотын стандартын баримт бичгийг 2022 оны 3 дугаар улиралд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд танилцуулан батлуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>Хотын стандартын баримт бичгийн төсөлд Нийслэлийн нутгийн захиргааны болон харьяа нийт 651 байгууллагад албан бичиг хүргүүлж, иргэд олон нийтээс цахим хуудсаар дамжуулан санал авч баримт бичигт тусган ажиллав.</p> <p>Мөн иргэдийн амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 2022 оны 2 дугаар сард дараах судалгааг хийв. Үүнд:</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээ шаардлагыг хангасан зам талбайтай эсэх судалгааг гарган, хотын стандартын арга зүйн баримт бичиг батлуулсан.</p>	90	Үгүй

			<ul style="list-style-type: none"> • Хороо, ерхийн эмнэлгийн цогцолбор барилга нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлын судалгаанд 171 хороог хамруулсан. • Ерөнхий боловсролын сургуулийн 305 байршилд гадна орчны судалгаа • Хүүхдийн цэцэрлэгийн 241 байршилд гадна орчны судалгаа <p>Дээрх судалгаагаар нийт 717 байршлаас 486 байршил хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам талбайгүй, замын налуу стандартын шаардлага хангаагүй байсан бөгөөд судалгааны үр дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 3 дугаар хурлаар хэлэлцүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын тогтоол</p>			
6	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх;	-	-	-	-
7		5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх;	Байгууллагын албан ёсны цахим хуудас болох www.standard.ub.gov.com -д газрын нэрийг үндэсний бичиг болон кирилл бичгээр бичиж байршуулав. Мөн цахим хуудсыг үндэсний бичиг болгохоор мэдээлэл технологийн байгууллагатай хамтран ажиллаж байна.	Байгууллагын цахим хуудсанд газрын нэрийг үндэсний бичиг болон кирилл бичгээр бичиж байршуулсан.	90	Үгүй
8		5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших;	Нийт албан хаагчдыг албан бичиг боловсруулахдаа кирилл болон үндэсний бичгээр хослуулан бичих талаар зөвлөмж өгч ажиллаж байна. Мөн нийт албан хаагчдыг үндэсний бичгийн анхан шатны мэдлэг өгөх сургалтанд хамруулан ажиллав.	-	50	Үгүй
9		5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний	Тус газраас нийт албан хаагчдыг хамруулсан анхан шатны хэсэгчилсэн үндэсний бичгийн цахим хичээлд 2022 оны 03	Албан хаагчдыг	50	Үгүй

		бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх;	дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн хамруулан ажиллаж байна.	сургалтанд хамруулав.		
10		5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	Тус газрын албан ёсны гадна хаягийг үндэсний бичиг болон крилл үсгээр хослуулан бичиж хаягжуулав.	Тус газрын албан ёсны гадна хаягийг үндэсний бичиг болон крилл үсгээр хослуулан бичиж хаягжуулав.	90	Тийм

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Э.ДАВААХАТАН

НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН



О.ӨНӨРБИЛЭГ